



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/418

Алтай хот

**Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг  
хориглох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "А", 29.2 дахь хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж хорио цээрийн хяналтад авах журам, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/174 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын зүүн, төв, баруун бүсийн зарим аймгуудад малын гоц халдварт болон олон улсын худалдааны хорио цээрт шүлхий өвчний халдвар илэрсэн тул өвчин дамжин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэл хугацаанд тухайн бүсийн халдвар илэрсэн аймгийн нутаг дэвсгэрээс мал, амьтан нэвтрүүлэх, шилжилт хөдөлгөөн хийхийг хориглосугай.

2. Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандах, тархвар зүйн судалгаа хийх ажлыг жил бүр зохион байгуулж, сумдын Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Мал эмнэлгийн газар (Д.Наянбуу)-т даалгасугай.


3. Мал амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг чангатган Мал эмнэлгийн нэгдсэн системийг тогтмол хянаж илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэж ажиллахыг аймаг, сумдын мал эмнэлгийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, малчид, мал бүхий иргэд, хуулийн этгээдэд сурталчилж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Ж.Мөнхцэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар), Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир), Онцгой байдлын газар (Л.Баянбаатар), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

6. Дээрх захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 148 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

02011360